# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 08 сарын 11 өдөр Дугаар 261 Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтэц, орон тоо, нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм"-ийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн нэгжүүдийг дараах байдлаар тогтоосугай:

1.1. Үнэт цаасны газар

1.2. Даатгалын газар

1.3. Банк бус санхүүгийн байгууллагын газар

1.4. Хадгаламж зээлийн хоршооны газар

1.5. Хяналт шалгалт, зохицуулалтын газар

1.6. Захиргаа удирдлагын газар

1.6.1. Санхүү, хөрөнгө оруулалтын алба

1.7. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар

1.7.1. Хэвлэл мэдээллийн алба

1.8. Судалгаа, эрсдлийн шинжилгээний хэлтэс

1.9. Хууль, эрх зүйн хэлтэс

1.10. Мэдээллийн технологийн хэлтэс

001285

1.11. Дотоод хяналтын хэлтэс

2. Ажлын албаны бүтцийг 144 хүний орон тоотойгоор баталж, бүтэц, зохион байгуулалтыг нэгдүгээр хавсралтаар, нэгжүүдийн ажлын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн өдрийн 262 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн зохион байгуулж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.

ДАРГА С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 261 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

# Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт /төсөл/

